



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 1/65

Амардалай

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дах заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх заалт, 38.4 дэх заалтууд болон газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрцогт сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр (Туулайн хонд)-д байршилтай иргэн Пунцаг овогтой Баасансүрэн (ЗЕ87061909)-ын 5000 м.кв (0.5 га) өвөлжөө, хаваржааны зориулалттай газрыг Оюунчимэг овотой Батсайхан (ЗЕ74070332)-д өмнөх эзэмшигчийн газрын зориулалт, хугацаагаар 5 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 05 тоот захирамжийн П.Баасансүрэн-д холбогдох хэсгийг мөн газар эзэмших 000457164 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгон газрын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

4. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүй зориулалтын дагуу эзэмшихийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

